



ЭРЧИМ

МЭДЭЭ

“ДЦС-4” ТӨХК-ийн сар тутмын сонин

№11 (139)

2022 оны 11-р сар

ЭНЭ ДУГААРТ:

2022 ОНЫ 11-Р САРЫН ТЭЭЗҮ

2-р нүүрт

2022 ОНЫ 11-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

3-р нүүрт

PENETRATION TEST БУЮУ НЭВТРЭХ ШАЛГАЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

4-р нүүрт

СПОРТ МЭДЭЭ

5-р нүүрт

"ДЦС-4" ТӨХК-Д ХҮН, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, БАРАА МАТЕРИАЛ ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ

6-7-р нүүрт

ХОДООД ГЭЖ ЯМАР ЭРХТЭН БЭ? Хеликобактери гэж юу вэ?

8-р нүүрт



Сонины талаарх санал хүсэлтээ 2125, 2602 дугаарын утас, sxa@tpp4.mn эсвэл Судалгаа Хөгжлийн Албанд файлаар болон бичгээр өгч болно.

www.tpp4.mn

“ТАГНУУРЧДЫН УР ЧАДВАР-2022”

ММСГН-ээс зохион байгуулсан Монголын мэргэжлийн гагнуурчдын улсын аварга шалгаруулах 6 дахь удаагийн тэмцээн 2022 оны 12-р сарын 01-04-ны хооронд Герман Монголын МСҮТ дээр болж өндөрлөлөө.

Тэмцээнд эрчим хүч, уул уурхай, иргэний нисэх, төмөр зам, МСҮТ-үүд зэрэг салбаруудын 26 байгууллага болон хувиараа оролцогсод, нийт 80 гаруй шилдэг гагнуурчид ур чадвараа сорин оролцлоо. Оролцогсдын хамгийн залуу нь 17 настай, ахмад нь 44 настай байлаа. Мөн эмэгтэй гагнуурчин 1 оролцлоо. Өмнө нь болсон улсын аваргын тэмцээний болон олон улсын ARC CUP тэмцээний медальтнууд, мөн МСҮТ төгссөн 23 хүртэлх насны гагнуурчдын дунд зохиогддог дэлхийн ур чадварын WORLDSKILSS тэмцээний Бразил, АНЭУ, ОХУ, АНУ-д зохиогдсон тэмцээнд Монгол улсаас шалгаран оролцсон. Монгол улсын үндэсний ялагч нар байсан нь энэ тэмцээнийг өрсөлдөөн ихтэй болгосон юм.


Тус тэмцээн

1. Бүрхүүлт электродтой гар нуман гагнуур (111/SMAW) буюу цахилгаан гар нуман гагнуур.
2. Идэвхтэй хийн хамгаалалттай нуман (135/GMAW) гагнуур буюу хагас автомат гагнуур
3. Идэвхгүй хийн хамгаалалттай вольфрам электродтой нуман гагнуур (141/GTAW) буюу аргон гагнуур гэсэн 3 төрлөөр явагдав.

Тус тэмцээнд “ДЦС-4” ТӨХК-ийн зүгээс аргон гагнуурын төрөлд 2 гагнуурчин, цахилгаан гагнуурын төрөлд 6-н гагнуурчин



оролцож аргон гагнуурын төрөлд Ч.Агваандэмбэрэл 1-р байр, цахилгаан гагнуурын төрөлд Э.Батсүх 2-р байр, Б.Оргил 3-р байр, С.Мөнх-Эрдэнэ 4-р байр эзэлсэн амжилт үзүүлснээр “ДЦС-4” ТӨХК-ийн гагнуурчид ур чадвараа харуулан багийн дүнгээр ТЭРГҮҮН БАЙР эзэлж 2022 оныг бахдам сайхан амжилтаар үдэж буй үйл явдал боллоо. Мөн эхний байруудад орсон 35-аас доош насны шилдэг гагнуурчид 2023 онд Бээжин хотод явагдах олон улсын гагнуурчдын “ARC CUP” тэмцээнд оролцох юм.



2022 ОНЫ 11-Р САРЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төлөвлөгөөний биелэлт

Горимын даалгавараас 8313,828 мян.кВтц цахилгаан эрчим хүч илүү үйлдвэрлэж, 3702,662 мян.кВтц-аар зөрчиж, төлөвлөгөөг 4611,166 сая.кВтц-аар давуулан биелүүлсэн. Цахилгаан эрчим хүчний доод ачаалал 540МВт, дээд ачаалал 675 МВт байлаа.

Диспетчерийн графикийн төлөвлөгөөний биелэлт

Үзүүлэлт	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт,%
ЦЭХ-ний түгээлт	сая.кВтц	397.6	402.2	+4.6	101.2%
ДЭХ-ний түгээлт	мян.Гкал	496.1	496.1	-	100.0%

Тайлант хугацаанд диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө: ЦЭХ - **101.2%**, ДЭХ - **100,0%** биеллээ.

ДҮТ-ийн диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө болон биелэлт

Нэмэх шийдвэр		Хасах шийдвэр		Диспетчерийн графикийн зөрчил		Ачаалал		Диспетчерийн төлөвлөгөөний биелэлт	Диспетчерийн графикийн нэмэх зөрчил
Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Дээд	Доод	мян.кВтц	мян.кВтц
66	8313.828	25	861.89	8	3702.662	675	540	4611.166	60.0

11-р сард УСТ-д тусгагдсан ЦЭХ-ний түгээлтийг **18,8 сая.кВтц-аар** давуулан биелүүлсэн. ЦЭХ-ний боловсруулалт өнгөрсөн онтой харьцуулахад **8,1 сая.кВтц-аар өссөн** нь бүгд шөнийн бага ачааллын цагуудад байлаа. Мөн гадна агаар эрс хүйтэрсэн өдөр сүлжээний усны халууны горим барьж ажилласантай холбоотой цахилгаан ачаалал нэмэх боломжгүй үед “ДҮТ ХХК” -аас 60,0 мян.кВтц-н нэмэх зөрчил ноогдуулсан байна.

СПОТ зах зээлийн талаар

СПОТ арилжааны зах зээлд 84,688 мян.кВтц буюу 3,9 сая.төгрөгний цахилгаан эрчим хүч худалдаж, 463,821 мян.кВтц буюу 20,0 сая.төгрөгний ЦЭХ худалдан авч, авлага өглөгийн зөрүүгээр 16,2 сая.төгрөгний алдагдалтай ажиллалаа. Өссөн дүнгээр 173,1 сая.төгрөгний авлагатай.

Үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөний биелэлт

Цахилгаан эрчим хүчний түгээлтийг төлөвлөлтөөс 18,8 сая.кВтц-аар давуулан 104,9%-н биелэлттэй, оны эхнээс 177,9 сая.кВтц-аар давуулж, 105,1% -ийн биелэлттэй байна.

Үндсэн тоноглолын ажиллагаа

Горим ажиллагаанд 8 зуух, 7 турбин оролцсон. Сарын дунджаар 6,95 зуух, 6,95 турбинтэй ажиллаж бэлтгэл тоноглолгүй байлаа. 2/XI - нд зуух №8 -г их засвараас явуулж сүлжээнд залгасан.

Нүүрсний зарцуулалт /УСТ тарифт тусгагдсан нүүрснээс/

Уурхай	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт
Багануур	мян.тн	205.000	197.981	-7.019	96.5%
Шивээ-Овоо	мян.тн	190.000	192.758	2.758	101.4%
Бүгд	мян.тн	395.000	390.739	-4.261	98.9%

Мазутын зарцуулалт

Энэ сард 120 тн мазут түлэх төлөвлөгөөтэйгээс 177 тн-г түлж, 57 тн мазут хэтрүүлсэн.

Тайлант хугацаанд 10 удаагийн хүйтэн галлагаа хийж 169 тонн, 1 удаагийн халуун галлагаа хийж 5 тонн мазут түлсэн.

Нэг хүйтэн галлагаанд дунджаар 17 тонн мазут зарцуулсан. Энэ сард зуухнууд халах гадаргуугын гэмтлээр 9 удаа зогссон нь мазут хэтрэх шалтгаан болсон.

Жишмэл түлшний зарцуулалт

Цахилгаан эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлшийг 244 тонн

Дулааны эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлшийг 217 тонноор тус бүр хэмнэсэн нь 3223 ккал/кг дундаж илчлэгтэй 999 тонн бодит түлш болсон.

Горим параметрийн даалгаврын биелэлт

ЭХЗХ -аас батлагдсан ДХЦЭХ-ний зарцуулалтыг 0,16%-иар буюу 733,319 мян.кВтц-аар хэмнэж ажилласан.

Тайлант сард трансформаторын алдагдлыг 0,08% бууруулж ажиллалаа.

Нэгж бүтээгдэхүүнд оногдох ЦЭХ-г гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөө, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй тус, тус харьцуулбал:

№	Үзүүлэлт	Нэгж	11-р сар	
			Төлөв	Гүйц
1	1 тн нүүрс нунтаглахад зарцуулах цахилгаан	кВтц/ тн.нүүрс	28.77	28.36
2	1 тн уур боловсруулахад зарцуулах үлээлт соролтын цах.	кВтц/ тн.уур	4.53	4.46
3	1 тн тэжээлийн ус шахахад зарцуулагдах цахилгаан	кВтц/ тн.тэж ус	8.30	8.18
4	Эргэлтийн усны насос зарцуулагдах цахилгаан	%	1.08	1.07
5	Дулаанжуулалтын насос зарцуулагдах цахилгаан	кВтц/ тн.сүлж.ус	0.61	0.60

Уур усны алдагдал

Станцын дотоод циклийг нөхөх химийн цэвэрлэсэн усны зарцуулалтыг төлөвлөлтөөс 0,1% буюу 2028 тонноор хэмнэж ажилласан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад химийн цэвэрлэсэн усны зарцуулалт 5088 тонноор өссөн байна. Осмосын халаагч уурын зарцуулалт 4374 тн байлаа

Дотоод циклийн алдагдлыг нөхөхөөр:

- Турбинд - **54114 м³**
- Зууханд - **628 м³** ус өгсөн.
- БКБ-аас цэвэрлэгдсэн конденсатын зарцуулалт - **14626 м³** байлаа.

2022 ОНЫ 11-Р САРЫН ХЯНАЛТЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2022 оны 11-р сард станцын хэмжээний аваари, 1 болон 2-р зэргийн саатал гараагүй, үндсэн тоноглолын зогсолт 11 бүртгэгдсэнээс зуух 10 удаа, турбин 1 удаа тус бүр зогссон. Хүний буруутай үндсэн тоноглолын зогсолт гараагүй.

Үндсэн тоноглол зогссон шалтгааныг ангилан үзвэл:

№	Зогсолтын шалтгаан	Хамгаалалтаар		Захиалгаар		Бэлтгэлд		Саатал, гэмтлээр		Нийт зогсолт	
		2021 оны 11-р сар	2022 оны 11-р сар	2021 оны 11-р сар	2022 оны 11-р сар	2021 оны 11-р сар	2022 оны 11-р сар	2021 оны 11-р сар	2022 оны 11-р сар	2021 оны 11-р сар	2022 оны 11-р сар
1	Зуух	3	2	1	1	1	-	1	7	6	10
2	Турбин	1	-	1	-	1	-	1	1	4	1
	Дүн	4	2	2	1	2	-	2	8	10	11

Үндсэн тоноглолын зогсолт болон туслах тоноглолд бичигдсэн актууд:

- Тоног төхөөрөмжийн гэмтлийн акт: МЦ-1 /2,589.2 мян₮/ бүгд-1 /2,589.2 мян₮/
- Мазут зарцуулалтын акт: ЗЦ-5 /169,400.2 мян₮/ бүгд-5 /169,400.2 мян₮/
- Тоног төхөөрөмж сэлбэг материал ашиглалтаас хасах акт: бүгд-6 ТЦ-1, ТДЦ-1, YA-2, ЭЗЦГ-1, ЗЦ-1 Нийт 12 ширхэг /193.395,154 мян₮/ акт тогтоогдсон.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ

1. Хяналтын чиглэлээр

№	Хийгдсэн ажил	Гүйцэтгэл	Тайлбар
1	Нарядын мөрдөлтөнд хяналт хийсэн байдал	100%	30 нарыдад сонголтоор хяналт хийсэн.
2	Ажлын байранд хяналт хийсэн байдал	100%	Ажлын байранд тогтмол хяналт хийсэн.
3	Шинэчлэл, засварын ажлын явцад хяналт хийсэн байдал	100%	ППУ тэжээх усны "А" шугам шинээр солих, ДШС NaI филтр №3-т химийн хамгаалалт хийх, Үнсний 1-р шугамын засвар, 2Т трансформаторын засварын ажилд хяналт тавьж ажилласан.

2. Сургалт, зааварчилгаа

1	Урьдчилсан зааварчилгаа өгөгдсөн байдал	100%	144 хүнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
2	Шинээр ажилд орж байгаа иргэний сургалтын талаар	100%	10 иргэнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
3	Ажлын байр өөрчлөгдсөн ажилтны сургалтын талаар	100%	3 ажилтнаас шалгалт авсан.

3. ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР

1	МХЕГ ХАБҮЛ лабораторитой байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих.	100%	Тогтмол хяналт тавин ажиллаж байгаа. МХЕГ-ын ХАБҮЛ лабораторид Ундны ус-3, агаар-2 сорьц, хоол-10, /нян, хими/ арчдас-10 тус тус авч шинжилгээнд өгсөн. Шинжилгээний хариу хэвийн үзүүлэлттэй гарсан.
2	Хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийх.	100%	Үндсэн цехүүдэд хөдөлмөрийн нөхцлийн болон гэрэлтүүлэгийн хэмжилт хийгдсэн.
3	Ариутгал халдваргүйтгэлийн талаар	100%	"Стандарт" ХХК XI/14-16-ны хооронд нийт 93 цэгт ундны усны шүүлтүүр сольсон. Хяналт тавьж ажилласан:
4	Шавьж устгал, ундны усны шүүлтүүр солих ажилд хяналт хийгдсэн байдал.	100%	Ахуйн байрууд, бүх агуулахууд, галын байцаагчийн өрөө, ШТС -ын байруудад хулганы наалддаг болон Флакмафен үрлэн хор тавьсан.
5	Тоосролтын хэмжилтэнд хяналт хийсэн байдал	100%	Нийт 4 удаа хэмжилт хийгдсэн.

4. БУСАД АЖЛЫН ТАЛААР

- ЭХЯ -ны өргөтгөсөн шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт гаргаж ЗХНА-д өгсөн.
- Ослын мэдээлэл даалгавар №5, ХАБ-ын 3-р улирлын III шатны үзлэгийн гүйцэтгэл гаргасан
- ИТА нарын ээлжит ААД-ийн шалгалтыг хангалтгүй өгсөн болон ээлжийн амралттай, хүндэтгэх шалтгаантай байсан ИТА нараас 11 дүгээр сарын 09-ны өдөр ЦЦ-ийн шуурхай
- өрөөнд дахин шалгалт авах ажлыг зохион байгуулсан.
- Нийт ажиллагсаас ХЭМАБ-н судалгааг цахимаар авсан.
- "Витафит" ХХК хор саармагжүүлэх шингэн хүнсний бүтээгдэхүүний талаар танилцуулгыг ХА зохион байгуулж ЭЗЦГ, ТЭЗХ, СБХ болон Цехийн ХАБ-ын инженерүүдэд оролцсон.

PENETRATION TEST БУЮУ НЭВТРЭХ ШАЛГАЛТ ГЭЖ ЮУ ВЭ?



Penetration test нь танай байгууллагын сервер, систем, сүлжээний түвшинд үүссэн эмзэг сул талыг ашиглан байгууллагын дотоод нууц өгөгдөл/мэдээлэлрүү хандах боломжтой байна гэдгийг нотлох шалгалт юм. Энэ төрлийн шалгалтыг хийлгэснээр байгууллагын чухал системүүд дээр үүссэн эмзэг байдлуудыг эрт илрүүлэх, ирээдүйд үүсэж болох эрсдэлүүдийг урьдчилан хаах зэрэг давуу талтай.

Нэвтрэх шалгалтыг хийх **blackbox**, **whitebox** гэсэн үндсэн 2 аргачлал байдаг бөгөөд **blackbox** нь захиалагч тал шалгалт хийлгэх системийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг үйлчилгээ үзүүлэгч талд өгөхгүй байх. Өөрөөр хэлбэл яг л хакерууд шиг танай системүүдийн талаарх мэдээллийг өөрсдөө интернэт болон бусад эх сурвалжаас цуглуулан шалгалт хийнэ гэсэн үг.

Харин **whitebox** аргачлал нь захиалагч тал шалгалт хийлгэх системийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүр цаашлаад тухайн систем дээр тест хийх зориулалттай аккаунтуудыг хүртэл үүсгэн өгч шалгалт хийлгүүлдэг. **Whitebox** аргачлалын давуу тал нь үйлчилгээ үзүүлэгч тал танай системийн талаар илүү их мэдээлэлтэй байх тусмаа илүү олон эмзэг байдал илрүүлэх боломжтой байдагт оршино.

Хэрвээ танай байгууллага **PCI-DSS**, **ISO27001** зэрэг стандартыг хэрэгжүүлэхээр бэлдэж байгаа эсвэл аль хэдийн хэрэгжүүлсэн бол тухайн стандартыг хэрэгжүүлж буй **score**-д орсон систем дээр дор хаяж жилдээ нэг удаа нэвтрэх шалгалт хийлгэсэн байх шаардлагатайг анхаарна уу.

Нэвтрэх шалгалт хийлгэх байгууллагаа хэрхэн сонгох вэ?

МАБ-ын эрсдэл нь байгууллагад маш өндөр хэмжээний санхүүгийн болон нэр хүндийн хувьд хохирол учруулдаг учраас тэдгээр эрсдэлийг бүрэн илрүүлэх чадамж бүхий зөв байгууллагыг сонгох нь яалтачгүй чухал шийдвэр юм. Сонголт хийхдээ дор хаяж дараах шалгуур үзүүлэлтүүдийг харж сонголтоо хийхийг санал болгож байна.

Нэвтрэх шалгалт хийх багийн гишүүдийн ур чадвар: Багийн гишүүд нь ямар төрлийн системүүд дээр ахисан түвшний шалгалт хийх чадвартай болон тэр нь нотолгоотой эсэх. Жишээлбэл: Монголын ёс зүйт хакерын ХаруулЗанги тэмцээнд ямар амжилттай оролцож байсан эсэх. Цаашилбал дэлхийн шилдэг **bug bounty platform** болох **HackerOne**, **BugCrowd** дээр ямар түвшний хэдэн цоорхой олж байсан зэргээр шалгуур үзүүлэлт хийж болно.

Багийн гишүүдийн ажлын туршлага: Багийн гишүүд нь одоо болон урьд нь танай байгууллагын ашигладаг системүүдийг ашиглаж, тохируулж байсан хангалттай олон жилийн бодит туршлага байхгүй бол тэдгээр системүүдэд хэрхэн аюулгүй байдлын **best practice** тохируулах зөвлөмж өгөх, мэдээллийн аюулгүй байдлын засаглал, процессийн алдааг олж харахдаа учир дутагдалтай байдаг.

Ёс зүй: Нэвтрэх шалгалт хийж буй компани болон багийн гишүүд нь өмнө нь ямар нэгэн байгууллага, хувь хүний мэдээллийн аюулгүй байдалд эрдэл учруулахуйц ёсзүйгүй үйлдэл хийж байсан эсэхийг судлаж үзэх.

Бид хэрхэн нэвтрэх шалгалт хийдэг вэ?
Бид нэвтрэх шалгалтуудыг ихэвчлэн **whitebox** аргачлалаар хийдэг бөгөөд нийтлэг жишгийн дагуу **Planning**, **Reconnaissance**, **Scanning**, **Gaining access**, **Analysis** гэсэн үндсэн 5 шатлалтайгаар хийнэ. Эдгээрийг дэлгэрэнгүй тайлбарлавал:

Planning: Аюулгүй байдлын шалгалт хийлгэх гэж буй байгууллагатай ямар **asset**-ууд буюу системүүдийг хамруулах, хэзээ ажлыг эхлүүлэх, нэвтрэх шалгалт хийх ажилтан тухайн байгууллага дээр сууж ажиллах учраас ширээ, сандал, сүлжээний холболт, сүлжээний хандалт зэргийг нээлгэн бэлдүүлэх шат юм.

Reconnaissance: Шалгуулах системийн талаарх мэдээллийг **active** болон **passive** байдлаар цуглуулна. Өөрөөр хэлбэл тухайн системийн **DNS** бичлэг, ямар програмчлалын хэл ашигласан, эх код **github** эсвэл **gitlab** дээр хэсэгчилсэн эсвэл бүхэлдээ байгаа эсэх зэрэг нэмэлт мэдээллүүдийг цуглуулах шат юм.

Gaining access: Энэ шат нь бидний хамгийн ач холбогдол өгдөг шат бөгөөд илэрсэн эмзэг байдлын 90%-ыг гар аргаар илрүүлдэг. Өөрөөр хэлбэл энэ шатанд тухайн системийн **feature** бүрийг хэрхэн ажиллаж байгааг маш сайн ойлгон шинжилж түүн дээр шалгалт хийдэг ба бизнес логик, **access control**, **server side** эмзэг байдлуудыг илрүүлэн тэдгээрийг ашиглаж ямар нууц өгөгдөлрүү хандах боломжтой, санхүүгийн ямар хохирол учрах боломжтой зэргийг нотлон харуулна.

Analysis: Дээрх шатуудад илрүүлсэн эмзэг байдлыг хэрхэн засварлах, цаашид мэдээллийн аюулгүй байдлын засаглалын хувь ямар сайжруулалтууд хийх шаардлагатай талаарх дэлгэрэнгүй зөвлөмж, тайланг бэлтгэн өгнө. Манай баг Монголын томоохон банк, үүрэн холбоо, бизнесийн байгууллагуудад дор хаяж 5 жил тасралтгүй мэдээллийн аюулгүй байдлаар ажилласан, хамтран ажилласан туршлагатай гэдгээрээ давуу юм.

Нэвтрэх шалгалт нь **score** буюу хамрах хүрээний хувьд хэр том байхаас шалтгаалан шалгалтыг хийж дуусгах хугацаа уртсаж болно.



СПОРТЫН МЭДЭЭ



ХӨВСГӨЛ-ЭРЧИМ

МОНГОЛЫН ВОЛЕЙБОЛЫН ХОЛБОО
ҮНДЭСНИЙ ДЭЭД ЛИГ-2022 | ТЭРГҮҮН БАЙР



Монголын Волейболын Холбооны “Үндэсний дээд лиг”-ийн тэмцээн

Монголын волейболын холбооны “Үндэсний дээд лиг”-ийн тэмцээн 10-р сарын 10-ны өдрөөс 12 дугаар сарын 9-ний өдрийг хүртэл 2 сарын хугацаанд үргэлжлэн явагдлаа. Тус тэмцээнд эрэгтэй 8, эмэгтэй 9 багийн нийт 240 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаа, тэсвэр тэвчээрээ шалган амжилттай өрсөлдөж аваргуудаа тодрууллаа. Энэ удаагийн Үндэсний дээд лигийн тэцээнд Япон, Солонгос, АНУ, БНКонго улс, БНКуба улс, Тайланд, Румын, Иран, Канад зэрэг 9 улсын 26 легионер тамирчид өрсөлдсөнөөрөө өмнөх жилүүдийн лигийн тэмцээнээс онцлог байлаа. Эрчим эрэгтэй багт 2, эмэгтэй багт 1 тамирчин БНКуба улсаас урьж тоглуулсан. Эрчимийн охидууд эгч нарынхаа алдрыг үргэлжлүүлж 12 жил завсарласны эцэст шинэчилсэн форматаар дахин зохион байгуулагдаж эхэлсэн “Үндэсний дээд лиг”-ийн тэмцээндээ аварга цолоо хамгаалснаар 12 дахь удаагаа “Дээд Лиг”-ийн аварга боллоо.

“Эрчим-БВТ” эрэгтэй багийн хувьд хагас шигшээ тоглолтонд шалгарч чадсангүй тэмцээнээ өндөрлүүлсэн бол “Хөвсгөл-Эрчим” багийн хувьд хагас шигшээ шатанд Энагурэ Террамед багийг 2:0 харьцаагаар хожиж, шигшээ тоглолтонд Улаанбаатар багтай шийдвэрлэх 5 тоглолтонд 3:2 харьцаагаар хожил байгуулж 2022 оны МВХ-ны “Үндэсний дээд лиг”-ийн аварга багаар тодорлоо.

ШИЛДЭГ ДАСГАЛЖУУЛАГЧ



А.ОЧГЭРЭЛ

Б.ДАРИНЧУЛУУН

ШИЛДЭГ ХОЛБОГЧ



Г.ТӨРМАНДАХ

Л.ХОСБАЯР

ШИЛДЭГ ХАМГААЛАГЧ



З.БҮЯНЖАРГАЛ

М.САНЧИРМАА

ШИЛДЭГ ЛИГОНЕР ТОГЛОГЧ



Alireza Abalooh Mohsen

Arlin Hechavarria Correoso

ШИЛДЭГ ҮНЭ ЦЭНЭТЭЙ ТОГЛОГЧ



Г.ХОНГОРЗУЛ

"ДЦС-4" ТӨХК-Д ХҮН, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, БАРАА МАТЕРИАЛ ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ

/Үргэлжлэл түрүүчийн дугаарт/

8.1 Компанийн ажилтанууд, иргэн, хувь хүн

8.1.1 Ажлын үнэмлэх болон түр нэвтрэх үнэмлэх, иргэний үнэмлэхийг биедээ авч явах

8.1.2 Хамгаалалтын салбарын алба хаагчийн шаардлагын дагуу бичиг баримт, тээврийн хэрэгслийг шалгуулах

8.2 Захиргаа хүний нөөцийн алба

8.2.1 Компанийн ажилчдад ажлын үнэмлэхийг олгох /АЗ-ЗХНА-02/

8.2.2 Гэрээ байгуулсан аж ахуй нэгжүүдийн ирүүлсэн албан бичгийг үндэслэн (АШБ-/СҮАЖ-ЗА-02/-17) ХАБЭА-н урьдчилсан зааварчилгаа авсан ажилчдад нэвтрэх "Түр нэвтрэх үнэмлэх"-ийг олгох /АЗ-ЗХНА-02/

8.2.3 Хамгаалалтын салбарт бүх ажилтны нэр, албан тушаал, утасны дугаарын мэдээллийг гаргаж өгөх

8.3 Хяналтын алба

8.3.1 Объектод нэвтэрсэн иргэд, гадны байгууллагын гэрээт ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч холбогдох албан тушаалтан нар хяналт тавьж ажиллах.

8.4 Засварын алба

8.4.1 Засварын ажилтай холбоотой объектод нэвтрэх тээврийн хэрэгслийн улсын дугаар, маркыг ЗА-аас урьдчилан хамгаалалтын салбарт бичгээр өгсөн байна.

8.4.2 Объектод орох, гарах бараа материалын баримт бичиг болон авч яваа бараа материал, ачаа тээшийг хамгаалалтын салбарт шалгуулах ба шаардлагатай бол бараа материал гаргах оруулах зөвшөөрөл өгсөн албан тушаалтанг байцуулан шалгуулна.

8.4.3 Засварын албаны дарга /засварын үйл ажиллагаатай холбоотой тээврийн хэрэгсэл, бараа материал, багаж хэрэгсэл оруулж гаргах зөвшөөрөл/-ийг олгоно.

8.5 Судалгаа хөгжлийн алба

8.5.1 Техникийн шинэчлэл, судалгааны ажилтай холбоотой гадаад, дотоодын инженер, техникийн ажилчид, судалгааны багийг нэвтрүүлэхтэй холбоотой зөвшөөрлийг ЗХНА-ны даргад албан бичгээр хүсэлт гаргаж ажиллах.

8.6 Борлуулалт маркетингийн алба

8.6.1 Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан тарифаар борлуулах орлого, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын шийдвэрээр үнэ тогтоож борлуулах орлого гэрээгээр болон бусад эрх зүйн актаар зохицуулагдах орлогод хамаарах ажил үйлчилгээ, бараа, сэлбэг материалыг тээвэрлэх тээврийн хэрэгслийн орох зөвшөөрлийг гэрээ болон холбогдох зөвшөөрлийг журманд заасны дагуу олгож, хяналт тавьж ажиллана.

8.6.2 Өдөр тутмын гэмтэл устгах, их, урсгал засвар хийх үед шаардлагатай сэлбэг материалуудыг Хавсралт №13-ийн дагуу, харин энэ засварт шаардлагатай Хавсралт №18-ийн жагсаалтад заасан багажуудыг авч гарах тохиолдолд нэгжийн даргын хүсэлтээр СБХ-ийн дугаар өгсөн Хавсралт 14 дугаар маягтыг сар сараар урьдчилан авч тухай бүр бүрдүүлж ажиллана.

8.6.3 Үзлэг үйлчилгээ хийхээр ажлын цагаар шалган нэвтрүүлэх постоор орж гарах засварчид, гагнуурчид Хавсралт №19-ийн жагсаалтад заасан багажуудыг шалгуулахгүйгээр шалган нэвтрүүлэх 1,4,8,10 дугаар постоор нэвтрэнэ.

8.7 Санхүү бүртгэлийн хэлтэс

8.7.1 Засварын бараа материал, сэлбэгийг зөвхөн шалган нэвтрүүлэх 10 дугаар цэгийн гадна талд тээвэрлэн ирсэн үед хяналт тавьж бүртгэл хөтлөн оруулна

8.7.2 Үндсэн бус үйл ажиллагаанаас орлого олох, худалдан борлуулах бүртгэх, зарцуулах журамын дагуу жагсаалтад заасан худалдан борлуулж болох хуучин сэлбэг, бараа материалыг худалдан борлуулах үед хяналт тавьж ажиллана.

8.7.3 Үндсэн хөрөнгө, сэлбэг материалыг агуулахаас гадны компани зээлээр болон худалдан авах үед хяналт тавьж ажиллана.

8.7.4 Бараа, материал, тоног төхөөрөмж, захиалгат хоолыг шалган нэвтрүүлэх 10 дугаар цэгээр нэвтрэн гарах Зөвшөөрлийн хуудсанд дугаар өгч бүртгэн буцаж объектод орж байгаа эсэхэд хяналт тавьж 7 хоног бүрийн Ерөнхий инженерийн шуурхайд мэдээ гаргаж өгнө.

8.7.5 Тоног төхөөрөмж, багаж гаргах зөвшөөрөл бүхий хавсралт №14 маягтад урьдчилсан байдлаар цех, нэгжүүдэд тус тусад нь дугаар өгч, маягтын сарын хэрэглээг урьдчилан олгоно.

8.7.6 7 хоног бүр харуул хамгаалалтын салбараас дугаар өгсөн маягтуудын гүйцэтгэлд Хавсралт № 15-аар хяналт тавьж ажиллана

8.8 Төлөвлөлт эдийн засгийн хэлтэс

8.8.1 Засварын бараа материал, сэлбэгийг зөвхөн шалган нэвтрүүлэх 10 дугаар цэгийн гадна талд тээвэрлэн ирсэн үед хяналт тавьж бүртгэл хөтлөн оруулна

8.8.2 Хоёрдогч түүхий эдийн агуулахаас хуучин сэлбэг материал худалдан борлуулах гэрээний дагуу болон, ажиллагсадын хүсэлт, зөвшөөрөл олгосон үед хамгаалалтын салбарын постоор хуучин сэлбэг материал авч гарах үед бараа материалын марк, төрөл, тоо хэмжээ, жинд хяналт тавьж ажиллана.

8.8.3 Цех нэгжүүдийн хүсэлтээр дотроос шинэ сэлбэг материал тээвэрлэн хамгаалалтын салбарын постоор гарах үед бараа материалын тоо хэмжээнд хяналт тавьж бүртгэж ажиллана.

8.8.4 Засварын гэрээ дүгнэж комиссын шийдвэр гарсан үед гадны компаниудын илүү гарсан сэлбэг материалыг гадагш авч гарах тохиолдолд сэлбэг материалын тоо хэмжээнд хяналт тавьж ажиллана.

8.9 Худалдан авах ажиллагааны хэлтэс

8.9.1 Худалдан авч буй бараа материалыг нэвтрүүлэхдээ Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга "Бараа материал нэвтрэн оруулах зөвшөөрөл"-ийг олгоно.

8.9.2 Объектод орох, гарах бараа материалын баримт бичиг болон авч яваа бараа материал, ачаа тээшийг хамгаалалтын салбарт шалгуулах ба ХААХ-ын мэргэжилтэн өөрийн хариуцсан бараа материалыг хүлээн авч шалган нэвтрүүлэх 10 дугаар постоор нэвтрүүлнэ.

8.9.3 Тендер шалгаруулах журамтай холбоотой тендерийн үнэлгээний хорооны хөндлөнгийн аудит нарыг нэвтрүүлэх зөвшөөрлийг олгож ажиллана.

8.9.4 Тендер шалгаруулах ажилтай холбоотой гадны байгууллагуудын ажиллагсадыг харуулын постоор нэвтрүүлэх зөвшөөрлийг олгож ажиллана.

"ДЦС-4" ТӨХК-Д ХҮН, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, БАРАА МАТЕРИАЛ ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ

8.10 Нийгэм ахуйн хэлтэс

8.10.1 Компанийн нутаг дэвсгэрт зохион байгуулагдаж буй хурал, уулзалт, олон нийтийн арга хэмжээнд оролцож буй зочид төлөөлөгчдийн тээврийн хэрэгслийг НАХ-ийн дарга нэвтрэх бичгийг олгоно.

8.10.2 Барилга, байгууламжийн засварын ажлын гэрээ байгуулсан аж ахуй нэгжүүдэд шаардлагатай зөвшөөрлийн хуудсыг олгоно.

8.10.3 Өвлийн улиралд шалган нэвтрүүлэх 10 дугаар постоор нэвтрэх дулаан зогсоол ашиглах хувийн тээврийн хэрэгслийн жагсаалтын Ерөнхий инженерээр батлуулан хамгаалалтын салбарт өгөх.

8.11 Авто аж ахуй

8.11.1 Шалган нэвтрүүлэх 10 дугаар постоор нэвтрэх хувийн тээврийн хэрэгслийг жагсаалтыг жил бүр гүйцэтгэх захирлаар шинэчлэн батлуулж хамгаалалтын салбарт өгөх.

8.11.2 Компанийн бүртгэлтэй болон гэрээт жолооч нарын тээврийн хэрэгслийн жагсаалтыг ААА-н дарга жил бүр гаргаж харуул хамгаалалтын салбарт өгөх.

8.11.3 Ахуйн хог хаягдал ачсан автомашин био комбинат руу, үнсний шлакийг ачсан тээврийн хэрэгсэл НОВ руу тээвэрлэж буулгана.

8.11.4 Ажиллагсадын автобус шалган нэвтрүүлэх 10 дугаар цэгийн гадна талд хүнээ буулгана.

8.11.5 Жолоочоос өөр хүн тээврийн хэрэгсэл дотор сууж шалган нэвтрүүлэх постоор гаргахгүй, шалган нэвтрүүлэх 10 дугаар постоор явганаар бууж орж гарна.

8.11.6 Замын түгжрэл болон зам тээврийн аюулгүй байдалтай холбоотой том оврын машин механизмууд шалган нэвтрүүлэх 7 дугаар постоор нэвтрэх цех нэгжүүдийн үйлчилгээнд компанийн хашаан дотор хөдөлгөөнд оролцоно.

8.12 Эрчим зоог цайны газар

8.12.1 Компанийн ажиллагсадаас ирсэн зохих зөвшөөрөлтэй хүсэлтийн дагуу захиалгат хоол хийх зөвшөөрлийг олгоно.

8.12.2 Эрчим зоог цайны газрын хоолны борлуулалт хүнсний материал хүлээн авах, зарцуулах, бүртгэх журамын 6.6.10 дугаар заалтыг мөрдөж ажиллана.

8.13 Цехүүд

8.13.1 Алсагдсан аж ахуй болон компанийн хашааны гадна талд их, урсгал засвар хийх, гэмтэл устгахаар сэлбэг материал, батлагдсан жагсаалтад ороогүй багаж хэрэгсэл авч гарах үед Хавсралт №13-ийн дагуу хүсэлт гарган Ерөнхий инженерээс зөвшөөрөл авч ажиллана.

8.13.2 Алслагдсан аж ахуйд гэмтэл устгах, их, урсгал засвар хийх үед авч гарах багажуудыг цехийн дарга нарын хүсэлтээр СБХ-ээс дугаарласан Хавсралт №14 дүгээр маягтыг урьдчилан сарын хэрэглээгээ ханган авч 6.5.4 дүгээр заалтыг хэрэгжүүлж ажиллана.

8.14 Хамгаалалтын салбар

8.14.1 Хамгаалалтын салбар нь объектын захиргаанаас журамд заасны дагуу олгосон зөвшөөрлийн дагуу гадны хүн

ба тээврийн хэрэгслийг нэвтрүүлнэ.

8.14.2 Объектод орох, гарах бараа материалын баримт бичиг болон авч яваа бараа материал, ачаа тээшийг шалгах ба шаардлагатай бол бараа материал гаргах оруулах зөвшөөрөл өгсөн албан тушаалтныг байлцуулан шалгах.

8.14.3 Объектод нэвтрэх байгаа ажилтан ажиллагсад, гадны иргэдийн нэвтрэх үнэмлэхийг шалгаж нэвтрүүлэх

8.14.4 Объектод явганаар нэвтрэн орж гарч байгаа хүмүүсийн овор ихтэй цүнх, сав, баглаатай эд зүйлсийг шалгаж үзэх ба шаардлагатай бол гар цүнх, биед үзлэг хийх

8.14.5 Худалдан авч буй бараа материалыг байгууллагын объект уруу нэвтрүүлэхэд "Бараа материал нэвтрэн оруулах зөвшөөрөл"-ийн хуудсыг үндэслэж барааны аюулгүй байдлыг шалгаж оруулах

8.14.6 Объектод зөвхөн журамд заасны дагуу зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх ба тээврийн хэрэгслийг бүрэн зогсолт хийсний дараа жолоочийг байцуулан бараа материалыг дагалдах баримт бичиг, зөвшөөрлийн бичигтэй нь тулган шалгах

8.14.7 Тээврийн хэрэгсэлд яваа бусад иргэдийг машинаас буулгаж явганаар шалгаж нэвтрүүлэх.

8.14.8 Объектод нэвтэрсэн гадны иргэд, тээврийн хэрэгсэл, бараа материалыг шалган нэвтрүүлэх бүртгэлд бүртгэх

8.14.9 Объектоос Хавсралт №13-аар зөвшөөрөлтэй гарсан буцаж орно гэсэн тодотголтой, Ерөнхий инженерийн цохолттой бараа, материал, сэлбэг хэрэгсэл, багажуудыг буцаж орсон эсэхэд хяналт тавьж ажиллана.

8.14.10 Объектоос Хавсралт №14-аар зөвшөөрөлтэй гарсан багажуудыг буцаж орсон эсэхэд хяналт тавьж, тайланг 7 хоног бүр СБХ-ийн ахлах ня-бод тайлагнана.

8.14.11 Засварын сэлбэг материал болон худалдан авалтын сэлбэг, төрөл бүрийн бараа материалыг ачиж орсон тээврийн хэрэгслүүдийг буцааж гарах үед хамгаалалтын салбар хяналт тавьж ажиллана.

8.14.12 Шалган нэвтрүүлэх цэгээр





8.14.13 Суудлын авто машины дотор болон багаажны хэсгийг заавал шалгах ба шаардлагатай бол капотын хэсэгт үзлэг хийх

8.14.14 Объектод хүн, бараа материал, тээврийн хэрэгслийг шалгах явцад илэрсэн зөрчил дутагдал, зөрчил гаргасан этгээдийн талаар объектын удирдлагад тухай бүр нь танилцуулах

8.14.15 Компанийн авто зогсоол дээр байрлуулсан хувийн болон гадны тээврийн хэрэгслийг теле камер ашиглан хянах бөгөөд зөрчил илэрсэн даруйд гадагш нэвтрүүлэхгүйгээр шалгаж, шалтгааныг тогтоох.

8.14.16 Дотоодын цэргийн ахлагч, харуулын ахлагч нар компанийн ажиллагсадтай зөв боловсон харьцаж, хяналтыг тасралтгүй тавьж сэжигтэй байдал илэрсэн тохиолдолд хамгаалалтын салбарын дарга, компанийн удирдлагад нэн даруй мэдэгдэх.

THAT MIGHT MOTIVATE YOU №9







ХОДООД ГЭЖ ЯМАР ЭРХТЭН БЭ?

Ходоодонд хоол боловсрох нь...

Ходоодны шарх, үрэвсэл, хавдар гэж юу вэ?

Хеликобактери гэж юу вэ? Түүний хор хөнөөл
Ходоодны хэмжээ, хооллох зарчим

хөдөлгөөний үйл ажиллагаа хямарч салст бүрхэвчийн хэсэг газар тэжээлийн дуталд орж шархлаа үүсдэг.




Хеликобактери гэж юу вэ?

Түүний хор хөнөөл Хеликобактер буюу *h-pylori* нь бактерийн маш хортой нэгэн хэлбэр бөгөөд мушгиа хэлбэрийн сахлаараа ходоодны салст бүрхүүлийг өрөмдөн, ходоодны дотор ханыг хамгаалагч салслаг бүрхүүл үүсгэдэг эсийг гэмтээдэг. Ингэснээр ходоодны ханыг хүчлээс хамгаалдаг салслаг бүрхүүл үгүй болж, ходоодны хүчил, бактерийн ялгаруулж буй шүүрлийн нөлөөгөөр ходоодны дотор хананд үрэвсэл үүсч дараа нь шархалдаг ажээ. Ходоодны хэмжээ, хооллох зарчим Жирийн хүний хоосон ходоодны эзэлхүүн 500мл. Яг л ийм хэмжээний хоолыг ходоод руу хийж болно. Ходоодыг 1 л болтол нь дүүргэлээ гэхэд асуудалгүй ноором хэмжээндээ нийцдэг. Ер нь хүний ходоод 4 л-ийг ч багтаах боломжтой боловч эд эрхтэн сунаж, сунасан ходоодондоо дассаар байнга хоол нэхдэг муу занд суралцана гэсэн үг.

Хооллох үедээ юуг анхаарах вэ?


- Өдөрт 4-өөс дээш удаа бага багаар тайван удаан хооллох
- Хоолоо хэт халуун, хэт хүйтэн идэхгүй байх
- Ханасан өөх тос, холестерол, давс, элсэн чихрийн хэрэглээг багасгах/ өдөрт 4гр буюу 1 цайны халбага давс/
- Эслэг ихтэй хоол хүнсийг хязгаартай хэрэглэх /бүтэн үрийн гурил, төрөл бүрийн ногооны гадна хальс, хальстай будаанууд/
- Хүнсний бүтээгдэхүүнийг сайтар болгож зутан хэлбэрээр хэрэглэх
- Хүнсний уураглаг бүтээгдэхүүнүүд болох мах, төрөл бүрийн шош буурцагт ургамлыг түлхүү хэрэглэх/ бүхлээр нь бус жижиглэж нунтаглаж/
- Хоол хийхдээ амьтны гаралтай тос хэрэглэхийн оронд ургамлын гаралтай тос хэрэглэх, хоолыг шарж болгохын оронд аль болох чанаж, жигнэж болгох
- Хурц амттай, аргуун, хатуу хоол, хатаасан бүтээгдэхүүн, шарсан хоол зэргээс аль болох зайлсхийх
- Сүү сүүн бүтээгдэхүүн нь ходоодны хүчлийг нэмэгдүүлдэг тул хязгаартай хэрэглэх/ өдөрт 150гр-ыг бага багаар/
- Архи, тамхи болон согтууруулах ундааг хэрэглэхгүй байх
- Хүчтэй эм бэлдмэл хэрэглэхдээ анхааралтай байж эмчийн хяналтын дор жорын дагуу хэрэглэх
- Өдөрт тогтмол 30-60 минут идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх.
- Өдөрт хэрэглэх усны хэмжээг нэмэгдүүлэх / 8 аяга буюу 1,5-2л ус/



Ходоодонд хоол боловсрох нь:

Ходоод нь хоол боловсруулах хүчил ба зарим ферментүүдийг ялгаруулдаг. Ходоодны хананд дахь булчин нь агшиж хоолыг хүчил ба ферментүүдтэй хольж арван хоёр хуруу гэдэсрүү (нарийн гэдэсний эхний хэсэг) түлхэж өгдөг. Энд ирсэн хоол нь нойр булчирхай болон цэсний замаас ялгарсан нэмэгдэл ферментүүдтэй нэгддэг. Эдгээр ферментүүд нь хоолыг (задалж) боловсруулдаг. Боловсрогдсон хоол нь нарийн гэдэсээр дамжин биед шимэгддэг.

Ходоодны шархлаа, хавдар гэж юу вэ?



Ходоодны шарх

Хавдар гэж: Хүний биеийн эсүүдийн өвчин юм. Бие махбод нь сая сая өчүүхэн эсүүдээс бүрддэг. Биед олон төрлийн эсүүд байх бөгөөд янз бүрийн төрлийн эсүүдээс бий болсон төрөл бүрийн хавдар байдаг. Бүх төрлийн хорт хавдрын нийтлэг зүйл нь хавдрын эсүүд хэвийн бус ба "хяналтаас гадуур" олширдог явдал юм.

Шарх гэж: Ходоод гэдэсний шингэний зохицуулга, шүүрэл,

ЭЗЦГ Хоол зүйч Г.Пунсалмаа